

Хүн бүр эрүүл мэндийн даатгалаа холбогдох эрүүл мэндийн даатгалын байгууллагад төлөх үүрэгтэй!

Хэрэв тэр үүнийг төлөхгүй бол даатгалын кампани эсрэг өр (торгууль) үүсэж нэмэгдэх болно. Эдгээр төлбөрийн ачаар хүн бүр эмнэлгийн болон бусад холбогдох эрүүл мэндийн үйлчилгээг авах баталгаатай болно.

- Хэрэв та ажиллаж байгаа бол (хөдөлмөр эрхлэгч) ажил олгогч таны даатгалын шимтгэлийг төлөх үүрэгтэй.
- Хэрэв та ажил хийдэггүй (ажилгүй) тэгээд хөдөлмөр зуучлалын газрын бүртгэлд (зөвхөн байнгын оршин суух эрхтэй хүмүүс) байгаа бол даатгалын шимтгэлийг төрөөс төлнө.
- Хэрэв та ажил хийдэггүй (ажилгүй) мөн хөдөлмөр зуучлалын газарт бүртгүүлээгүй бол (зөвхөн байнгын оршин суух эрхтэй хүмүүс) даатгалын шимтгэлийг өөрөө төлнө.

Чех улсад эрүүл мэндийн даатгалыг НИЙГМИЙН болон АРИЛЖААНЫ эрүүл мэндийн даатгал гэж хуваадаг.

Эрүүл мэндийн даатгалд хамрагдсаны баталгаа нь "ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН ҮНЭМЛЭХ" бөгөөд үргэлж биедээ авч явах шаардлагатай. Арилжааны даатгалын хувьд үнэмлэхээс гадна төлбөр төлсөн баримтыг хамт авч явах шаардлагатай.

Нийгмийн эрүүл мэндийн даатгал	Цогц тусламж үйлчилгээний хүрээнд багтах арилжааны эрүүл мэндийн даатгал
<ul style="list-style-type: none">• байнгын оршин суух зөвшөөрөлтэй гадаадын иргэд	<ul style="list-style-type: none">• хувиараа бизнес эрхлэгчид (OSVČ) болон бусад бизнес эрхлэгчид
<ul style="list-style-type: none">• гадаадын иргэд – оршин суух зөвшөөрөл нь үл хамаарах ажилчид (виз, удаан хугацаагаар оршин суух зөвшөөрөл – ажлын карт)	<ul style="list-style-type: none">• ажил эрхлэгчдийн эдийн засгийн идэвхгүй гэр бүлийн гишүүд, хувиараа хөдөлмөр эрхлэгчид, мөн бусад гадаадын иргэд, тэр байтугай Чех улсын иргэд.
<ul style="list-style-type: none">• ЕХ-ны гишүүн орнуудын иргэд мөн тэдний гэр бүлийн гишүүд (тодорхой нөхцөлд)	<ul style="list-style-type: none">• сурагчид/оюутнууд

! Даатгалд хамрагдахаасаа өмнө гэрээт эмч, эмнэлгийн үйлчилгээний жагсаалттай танилцахыг зөвлөж байна. Эмчилгээ хийлгэхийн дараа эмч танаас бэлэн мөнгө шаардах тохиолдол гардаг. Энэ тохиолдолд төлбөр төлөхийг шаардсан баримт болон төлбөр төлсөн баримтыг гаргуулж аваарай. Даатгалын компанид бичиг баримтаа бүрдүүлсний дараа эрүүл мэндийн тусламж үйлчилгээний зардлыг нөхөн төлдөг.

- Та эмч нарын жагсаалтыг эндээс олж болно: www.znamylekar.cz

Хэрэв та эрүүл мэндийн даатгалын өртэй бол нөхцөл байдлыг бүү орхи, харин үүнийг шийдээрэй!



Spolufinancováno
Evropskou unií



MINISTERSTVO VNITRA
ČESKÉ REPUBLIKY



Projekt "Centrum na podporu
integrace cizinců v Ústeckém kraji" reg.
č. CZ.12.01.02/00/23_008/0000008 je
financován OP AMIF a MV ČR.